



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2010 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 50

Улаанбаатар хот

Нийслэлийн зураг төслийн хүрээлэнг  
байгуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын “ж” заалт, Нийслэлийн Засаг даргын 2010 оны 1/494 тоот албан бичгээр өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. “Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн” нийслэлийн өмчит аж ахуйн тооцоот газрыг байгуулсугай.

Хоёр. Шинээр байгуулагдсан газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /Г.Мөнхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Т.БИЛЭГТ